



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/272

Сүхбаатар сум

┌ Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам"-ын 2.2.2 дахь заалт, 2021 оны мн/114 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны н/131 дүгээр тушаал, Батлан хамгаалахын сайд, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний 4.2 заалт, 2021 онд сумдын Засаг дарга аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 16.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг 10 дугаар сарын 06-аас 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын цэрэг татлагын байранд бүсчлэн зохион байгуулсугай.

2. Хоёрдугаар ээлжийн хугацаат цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар, цэрэг татлагын анкетыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. 2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад 1996 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2003 оны 10 дугаар сарын 16-ны хооронд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

4. Цэрэг татлагын анкетыг 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн тус бүрд бүртгэн шивж, "Байгууллагын баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт"-ын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа иргэдэд Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн үндсэн Цусны ерөнхий, шээсний ерөнхий, биохимийн (сахар, АСАТ, АЛАТ, креатинин, мочевин) элэгний В,С вирус илрүүлэх, ДОХ, тэмбүүгүйн, /Ковид-19/-ийн түргэвчилсэн шинжилгээг бүрэн хийлгэж, анкетад нь хавсарган өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

430810665

6. Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг хийх нарийн мэргэжлийн Дотор-халдварт, Гэмтэл-мэс засал, Нүд, Шүд, Чих хамар хоолой, Мэдрэл, Сэтгэц, Арьс өнгө, харшил, БЗДХ/ДОХ, Дүрс оношилгоо, Зүрх судас, Сүрьеэгийн эмч нарыг томилж, явах маршрутын дагуу унаагаар хангах, амралтын өдрүүдэд ажиллуулсан тохиолдолд нөхөн амраах, арга хэмжээг авч ажиллуулахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д үүрэг болгосугай.

7. Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, татагдагчдад Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/456 дугаар тушаалын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, голомтын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8. Цэрэг татлагын байрыг бэлэн болгох, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж, 2 цаг тутамд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх бүрэлдэхүүнийг томилгоожуулан ажиллуулахыг Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын Засаг дарга /Н.Лхагвадорж, Б.Мөнхболд, Т.Гантулга/ нарт даалгасугай.

9. Цэрэг татлагын байруудад нийгмийн даатгалын мэргэжилтнийг цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүний цагийн хуваариар ажиллуулж, цэргийн албанд тэнцэгчдийг нийгмийн даатгалын цахим бүртгэлийн мэдээллийн санд оруулах ажлыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга /С.Отгонжаргал /-д үүрэг болгосугай.

10. Цэрэг татлагын байруудад уэль / дуу өсгөгч / ажиллуулж олон нийтэд сурталчлах, тухайн өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байх арга хэмжээ авахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

11. 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучууд нэг бүрд зарлан дуудах хуудас гардуулан өгч, цэрэг татлагын байранд заасан хугацаа тогтоосон цагт бэлэн байлгах, тэдгээрийн цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, /Ковид-19/-ийн түргэвчилсэн шинжилгээний хариу, гэрийн шаахай /тавчиг/, 4-5 ээлжийн амны хаалт /маск/-тай, 2 хувь эрүүл мэндийн үзлэгийн анкет, 3 хувь цээж зураг бүрдүүлж ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

12. Цэрэг татлага зохион байгуулж буй суманд болон цэрэг татлагын байруудад, хугацаат цэргийн албанд тэнцсэн залуусыг аймаг орон нутгаас үдэн гаргах үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-д үүрэг болгосугай.

13. Цэргийн албанд тэнцэгчдийг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр PCR болон түргэвчилсэн шинжилгээнд бүрэн хамруулж, 10 дугаар сарын 19-нд шинжилгээний хариутай цэргийн штабт хүлээлгэн өгөхийг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, сумдын Засаг дарга нарт тус тус хариуцуулсугай.

6. Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг хийх нарийн мэргэжлийн Дотор-халдварт, Гэмтэл-мэс засал, Нүд, Шүд, Чих хамар хоолой, Мэдрэл, Сэтгэц, Арьс өнгө, харшил, БЗДХ/ДОХ, Дүрс оношилгоо, Зүрх судас, Сүрьеэгийн эмч нарыг томилж, явах маршрутын дагуу унаагаар хангах, амралтын өдрүүдэд ажиллуулсан тохиолдолд нөхөн амраах, арга хэмжээг авч ажиллуулахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д үүрэг болгосугай.

7. Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, татагдагчдад Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/456 дугаар тушаалын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, голомтын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8. Цэрэг татлагын байрыг бэлэн болгох, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж, 2 цаг тутамд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх бүрэлдэхүүнийг томилгоожуулан ажиллуулахыг Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын Засаг дарга /Н.Лхагвадорж, Б.Мөнхболд, Т.Гантулга/ нарт даалгасугай.

9. Цэрэг татлагын байруудад нийгмийн даатгалын мэргэжилтнийг цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүний цагийн хуваариар ажиллуулж, цэргийн албанд тэнцэгчдийг нийгмийн даатгалын цахим бүртгэлийн мэдээллийн санд оруулах ажлыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга /С.Отгонжаргал /-д үүрэг болгосугай.

10. Цэрэг татлагын байруудад уэль / дуу өсгөгч / ажиллуулж олон нийтэд сурталчлах, тухайн өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байх арга хэмжээ авахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

11. 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучууд нэг бүрд зарлан дуудах хуудас гардуулан өгч, цэрэг татлагын байранд заасан хугацаа тогтоосон цагт бэлэн байлгах, тэдгээрийн цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, /Ковид-19/-ийн түргэвчилсэн шинжилгээний хариу, гэрийн шаахай /тавчиг/, 4-5 ээлжийн амны хаалт /маск/-тай, 2 хувь эрүүл мэндийн үзлэгийн анкет, 3 хувь цээж зураг бүрдүүлж ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.


12. Цэрэг татлага зохион байгуулж буй суманд болон цэрэг татлагын байруудад, хугацаат цэргийн албанд тэнцсэн залуусыг аймаг орон нутгаас үдэн гаргах үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-д үүрэг болгосугай.

13. Цэргийн албанд тэнцэгчдийг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр PCR-ын шинжилгээнд бүрэн хамруулж, 10 дугаар сарын 19-нд шинжилгээний хариутай цэргийн штабт хүлээлгэн өгөхийг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, сумдын Засаг дарга нарт тус тус хариуцуулсугай.

14. 2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар цэргийн жинхэнэ албанд тэнцэж Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын харьяа анги байгууллагуудад алба хаахаар Сэлэнгэ аймгаас татагдагчдыг үдэн гаргах ёслолын арга хэмжээг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 19:00 цагт Сүхбаатар өртөөнд зохион байгуулахыг Хилийн 0243 дугаар ангийн захирагч хурандаа /Д.Мэндсайхан/, "Сэлэнгийн долгио чуулга"-ын дарга /Д.Уранбилэг/ нарт тус тус даалгасугай.

15. Гадаадад оршин суугаа Монгол Улсын 18-25 насны иргэдийн хилээр гарсан лавлагааг Хил хамгаалах ерөнхий газраас авч ирэхийг сумдын Засаг дарга нарт тус тус хариуцуулсугай.

ДАРГА Ш.ОРГИЛ

A square official stamp with a double-line border. Inside the stamp, there is a handwritten signature in the center. On the left side of the stamp, the word "ДАРГА" is written vertically. On the right side, "Ш.ОРГИЛ" is written vertically. The stamp is placed over the text of the 15th point.

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дүгээр сарын 14-ний өдрийн А/272-р
захирамжийн нэгдүгээр хавсралт

2021 ОНЫ ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНЫ ТАТЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Цэрэг татлагын товчооны дарга

Ө. Сувдаа

- Аймгийн Засаг даргын Тамгын
газрын дарга

Нарийн бичгийн дарга

Б.Энхболд

- Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын
дарга, дэд хурандаа

Гишүүд:

О.Мөнхбаяр

- Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн Сангийн
хэлтсийн дарга

Ж.Од

- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

А.Энхбат

- Аймгийн Цагдаагийн газрын
дарга, хурандаа

С.Отгонжаргал

- Аймгийн Нийгмийн даатгалын
хэлтсийн дарга

Т.Гантулга

- Сүхбаатар сумын Засаг дарга

Н.Лхагвадорж

- Мандал сумын Засаг дарга

Б.Мөнхболд

- Сайхан сумын Засаг дарга

Б.Батчулуун

- Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын
тоо бүртгэлийн офицер, ахмад

Аймгийн Засаг даргын 2021 оны
 09 дугаар сарын 14 -ний өдрийн А/ЗД-р
 захирамжийн хоёрдугаар хавсралт

2021 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАН
 ТАТЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Цэрэг татлагын байр	Сумууд цэрэг татлагын байранд ирэх хуваарь	Хариуцах эзэн
1	2	3	4
Нэг. Цэрэг татах ажлын хүрээнд			
1	Мандал сум	2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 09:00-13:00 цагт Мандал сумын 1, 2, 3 дугаар багууд, 14:00-17:00 цагт 7, 9 дүгээр багууд	Сумын Засаг дарга Н.Лхагвадорж, ЗДТГ болон багийн Засаг дарга нар
		2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 09:00-13:00 цагт Мандал сумын 4, 5, 6, 8 дугаар багууд	
		2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 09:30-14:00 цагт Баянгол сум	
2	Сайхан сум	2021 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 09:00-13:00 цагт Сант сум, Орхон сум, 14:00-18:00 цагт Орхонтуул, Баруунбүрэн сум	Сумын Засаг дарга Б.Мөнхболд, ЗДТГ болон багийн Засаг дарга нар
		2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 09:00-13:00 цагт Сайхан сумын 1,2 дугаар багууд	
		2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 09:00-13:00 цагт Сайхан сумын 3 дугаар баг	
3	Сүхбаатар сум	2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 09:00-13:00 Жавхлант, Хушаат сум, 14:00 - 17:00 цагт Ерөө, Хүдэр сум	Сумын Засаг дарга Т.Гантулга, ЗДТГ болон багийн Засаг дарга нар
		2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 09:00-13:00 цагт Шаамар, Зүүнбүрэн сум, 14:00-17:00 Түшиг сум	
		2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 09:00-13:00 цагт Цагааннуур, Алтанбулаг сум, 14:00-18:00 цагт Сүхбаатар сумын 1, 5 дугаар багууд	
		2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 09:00-13:00 цагт Сүхбаатар сумын 2, 3 дугаар багууд, 14:00-17:00 цагт 4, 6 дугаар багууд	
5	АЗДТГазрын Цэргийн штаб	2021 оны 10 дугаар сарын 17-ны 10:00-16:00 цагт Өргөдөл гомдол хүлээж авна.	Цэргийн штабын дарга д/х Б.Энхболд


Хоёр. Татагдагчдыг төв дамжинд хүлээлгэн өгөх ажлын хүрээнд			
д/д	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хугацаат цэргийн албанд тэнцэгчдийг тээвэрлэх, Хил хамгаалах байгууллагын төв дамжин өнгөрүүлэх баазад цэргийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, анги, салбарт хуваарилах	2021 оны 10 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд	Цэргийн штаб
3	2021 оны хугацаат цэргийн албан татлага зохион байгуулсан тухай тайлан, мэдээ, илтгэлийг БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтэст өгч, аймгийн Дайчилгааны төлөвлөгөөг тодотгох	2021 оны 10 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд	Цэргийн штаб

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЦЭРГИЙН ШТАБ

Аймгийн Засаг даргын 2021 оны
 09 дугаар сарын 14 -ний өдрийн №272-р
 захирамжийн гуравдугаар хавсралт

Нүүр тал

СЭЛЭНГЭ АЙМГИЙН _____ СУМААС 2021 ОНЫ ХОЁРДУГААР
 ЭЭЛЖЭЭР ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД
 ТАТАГДАГЧИЙН АНКЕТ



3*4

Регистрийн дугаар: _____
 Цэргийн үүрэгтний үнэмлэхийн: _____

Овог нэр				
Яс үндэс				
Үндсэн захиргаа				
Одоо / гэр/-гийн хаяг				
Цэргийн жинхэнэ албанд татагдахын өмнө хэдэн оноос хаана ямар албан ажил хийж байсан.				
Хэзээ хаана ямар сургууль төгссөн				
Энгийн мэргэжил, үнэмлэх дипломын дугаар				
Гэрийн доторх ам бүл хэд, таны юу болох, хэн,хэн хэдэн настай, хаана ямар ажилтай	Хэн болох	Овог нэр	Нас	Ажил
Өрх тусгай ах дүү,төрөл,садан, хэн хэдэн настай, хаана ямар ажилтай	Хэн болох	Овог нэр	Нас	Ажил
Ял шийтгэгдэж явсан эсэх				

Бүртгэсэн 202_ он ___ сар ___ өдөр

Бүртгэсэн 202_ он ___ сар ___ өдөр

Ар тал ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ХУУДАС

д/д	Төрөл мэргэжил	Эмч нарын комиссын үзлэгийн дүгнэлт.					
		202_ оны ___ сар ___ өдөр	Гарын үсэг	202_ оны ___ сар ___ өдөр	Гарын үсэг	Төв дамжин 2020__ оны ___ сар ___ өдөр	Гарын үсэг
1	Дотор-халдварт						
2	Гэмтэл-мэс засал						
3	Нүд /хараа, баруун, зүүн/						
4	Шүд						
5	Чих, хамар, хоолой /сонсгол, баруун, зүүн/						
6	Мэдрэл						
7	Сэтгэц						
8	Арьс өнгө, харшил, БЗДХ/ДОХ						
9	Дүрс оношилгоо						
10	Зүрх судас						
11	Сүрьеэ						
12	Ерөнхий эмчийн дүгнэлт						
13	Цэрэг татлагын товчооны шийдвэр						

Биеийн өндөр _____ жин _____

Хаана ямар эмчилгээ хийх шаардлагатайг бичих: _____

Багийн ЗД-ын тодорхойлолт: _____

Цагдаагийн газрын тодорхойлолт: _____

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА
 ДЭД ХУРАНДАА Б.ЭНХБОЛД